



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/204

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3, Усны тухай хуулийн 12.1.4, 12.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрхаан сумын "Аврага"-ын нуурын усны түвшин багасаж, бохирдож буй шалтгааныг тодруулж, асуудал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн  
дарга:

-Мэргэжлийн хяналтын газрын дарга

Гишүүд:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, хөдөө аж  
ахуй, Уул уурхай хариуцсан мэргэжилтэн

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын удирдлагын хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны  
асуудал хариуцсан мэргэжилтэн

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал  
жуулчлал хариуцсан мэргэжилтэн

-Хэрлэн голын сав газрын захиргааны ахлах  
Мэргэжилтэн

-Ус, цаг уур орчны шинжилгээний газрын ус,  
судлалын судалгааны инженер

-Татварын хэлтсийн орлогын тасгийн дарга

-Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны  
хяналтын улсын байцаагч

011008


2//.

-Мэргэжлийн хяналтын газрын Үйлдвэр  
үйлчилгээний хяналтын улсын байцаагч

-Стандарт, хэмжил зүйн хэлтсийн шинжээч

2. Нуурын усны түвшин багасаж, бохирдож буй шалтгааныг тодруулж танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА